



ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААРХ

“УЛААНБААТАРЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ”

Олон улсын VII бага хурал

Хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдөр

Байршил: Гадаад харилцааны яамны Зөвшилцөл танхим

Хэл: Монгол, Англи

2022 оны 06 дугаар сарын 23, Пүрэв гараг

08:30 - 09:00 Бүртгэл

09:00 - 09:45 **НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ**

*Модератор: Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын даргын үүрэг гүйцэтгэгч **Батсүрэнгийн МАНДХАЙ***

Нээлтийн үг: Гадаад харилцааны сайд **Батмөнхийн БАТЦЭЦЭГ**

Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал, профессор **Бэгзийн ДАВААДОРЖ**

Цахим мэндчилгээ, НҮБ-ын Улс төр, энх тайвныг бэхжүүлэх асуудал эрхэлсэн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч **РОЗМАРИ ДиКарло**

Дурсгалын зураг татуулах (хурлын нийт оролцогчид)

09:45 - 10:00 Кофе завсарлага (ГХЯ, Номин танхим)

10:00 - 12:30

ХУРАЛДААН 1: БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СОРИЛТ, БОЛОМЖ

Цар тахлын нөхцөл байдлаас үл хамааран их гүрнүүдийн геополитик, гео-эдийн засгийн өрсөлдөөн үргэлжилж, Солонгосын хойгийн нөхцөл байдал тодорхойгүйн улмаас Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын орчин ээдрээтэй хэвээр байна. Энэ хуралдаан бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаач нарт бүс нутгийн аюулгүй байдлын сорилт, боломжийн талаар санал бодлоо солилцох, хэлэлцэх платформ болно. *Аюулгүй байдалд нэн тулгамдаж буй сорилт, чиг хандлагыг хэрхэн тодорхойлох вэ? Энэ нь бүс нутгийн тогтвортой байдалд богино, дунд болон урт хугацаанд хэрхэн нөлөөлөх вэ?*

*Модератор: Стратеги судалгааны хүрээлэнгийн дэд захирал, **Др. Жаргалсайханы МЭНДЭЭ***

Доржжүгдэрийн МӨНХ-ОЧИР, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Стратегийн бодлого, дүн шинжилгээний газрын дарга

Брион ВИЛФРЕД, Канадын парламентын гишүүн асан

Др. ФАН Шяоажу, Хятадын Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэнгийн Зүүн хойд Ази судлалын хүрээлэнгийн захирал, эрдэм шинжилгээний профессор (цахим)

Проф. Доктор Рюдигер ФРАНК, Венийн их сургуулийн Зүүн Ази судлалын тэнхимийн Зүүн Азийн эдийн засаг, нийгэм судлалын профессор (цахим)

Др. Мимура МИЦУХИРО, Япон улсын Зүүн хойд Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн

Др. Ки-Жун КИМ, БНСУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийн хүрээлэнгийн ерөнхийлөгч

Константин ЗАТУЛИН, ОХУ-ын ТУХН-ийн орнуудын судалгааны хүрээлэнгийн захирал
Асуулт & хариулт

12:30 - 13:30 Өдрийн хоол (ГХЯ, Номин танхим)

13:30 - 15:30

ХУРАЛДААН 2: ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зүүн Хойд Азийн бүс нутагт аюулгүй байдлын нэгдсэн механизм үгүй ч итгэлцлийг бэхжүүлэхийн төлөөх хүчин чармайлт цөөнгүй гарч байдаг. Төрийн болон төрийн бус байгууллага ч энэ чиглэлд олон төрлийн санал, санаачлагыг дэвшүүлж хэрэгжүүлэхийг эрмэлзэж ирсэн.

Энэ хуралдаанаар бүс нутгийн болон бусад улсын мэргэжилтэн нар итгэлцэл бэхжүүлэх чиглэлд амжилттай хэрэгжиж буй арга хэмжээ, санаачилгын талаарх үзэл бодлоо хуваалцах, өнгөрсөн болон одоогийн үйл явц, тохиолдолд дүн шинжилгээ хийж, бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтвортой хэвшүүлэх талаар ярилцах болно. *Улс орнууд итгэлцлийг бэхжүүлэхэд үр дүнтэй хувь нэмэр хэрхэн оруулах вэ? Шилдэг туршилага, арга замын тухай?*

***Модератор: Жонатан Бэркшир МИЛЛЕР**, Канад улсын Макдоналд-Лорьер хүрээлэнгийн Энэтхэг-Номхон далайн хөтөлбөрийн захирал, ахлах судлаач*

Отгонбаярын МАШБАТ, Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал

Др. Сунгхүүн ЛИ, БНСУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийн хүрээлэн, ахлах судлаач

Юлия КРЯЧКИНА, ОХУ-ын Стратегийн судалгааны хүрээлэнгийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан

Др. Альбрехт ШНАБЕЛ, Аюулгүй байдлын салбарын засаглалын Женевийн төвийн (DCAF) Ази, Номхон далайн хэлтсийн дарга

Др. Грегори ГЛИСОН, Жорж С.Маршаллын Европын аюулгүй байдлын судалгааны төвийн профессор

Асуулт & хариулт

15:30 - 15:45 Кофе завсарлага (ГХЯ, Номин танхим)

15:45 - 17:00

ХУРАЛДААН 3: ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЭНХ ТАЙВНЫ ИРЭЭДҮЙ

НҮБ-ын Улс төр, энх тайвныг тогтоох асуудал эрхэлсэн газар (DPPA), залуучуудын төлөөлөлд бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын талаарх санал, зөвлөмжөө бодлого боловсруулагчидтай хуваалцах талбар болно. Энэ хуралдаанаар бүс нутгийн залуучуудын харилцаа холбоог бэхжүүлэх, нийтлэг үнэлэмжийг бий болгох, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг сурталчилж, үе хоорондын ялгааг арилгах талаар ярилцах болно. *Залуучуудын дуу хоолой бодлого боловсруулахад хувь нэмрээ оруулах боломжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ? Залуучуудын мэдлэгийг ямар салбарт тавих ёстой вэ?*

***Модератор: Др. Соня БАХМАН**, НҮБ-ын Улс төрийн хэрэг эрхлэх газрын Зүүн хойд Ази, Номхон далайн бүсийн багийн ахлагч*

Ижунь КИМ, БНСУ

Батбаярын ТЭНГИС, Монгол Улс

Юкако БАН, Япон улс

Асуулт & хариулт

18:30 – 20:30 Хүлээн авалт (Туушин зочид буудал, Соёмбо танхим, 5 давхар)

2022 оны 06 дугаар сарын 24, Баасан гараг

08:30 - 09:00 Бүртгэл

09:00 - 11:00 Дугуй ширээний уулзалт (Track I): Засгийн газрын төлөөлөгчдийн хаалттай хуралдаан (ГХЯ-ны 101 тоот өрөөнд)

09:00 - 10:00

ХУРАЛДААН 4: КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Цар тахал худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлд төдийгүй нийгэм, хувь хүний амьдралд нөлөөлж байна. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон улс орнууд цар тахлын нөлөөг бууруулахын тулд томоохон бодлогын арга хэмжээ, дэмжлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хуралдаанаар Зүүн Хойд Азийн улс орон болон олон улсын санхүүгийн байгууллагын эдийн засагч, бодлого боловсруулагч, бизнесийн төлөөлөгчдөд цар тахлын дараах эдийн засгийн хамтын ажиллагааны талаар бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэх платформ болно. *Бүс нутгийн эдийн засгийг тогтворжуулах, харилцаа холбоог сайжруулах, ирээдүйн хямралд бэлэн байхын тулд бүс нутгийн улс орон болон олон улсын санхүүгийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллах вэ?*

*Модератор: Баянжаргалын БЯМБАСАЙХАН, Монголын бизнесийн зөвлөлийн
дэд дарга*

Рустам Эмилжанович АСИЗБАЕВ, Кыргызстаны Стратегийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Захирал

Баасандаваагийн ДӨЛГӨӨН, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвийн гүйцэтгэх захирал

Намжилдоржийн ЭНХБАЯР, Стратеги судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн аюулгүй байдлын судалгааны төвийн дарга

Др. Шагдарын ЭНХБАЯР, ЗХА-ийн эдийн засгийн судалгааны хүрээлэн, ахлах эрдэм шинжилгээний ажилтан

Ясин ЖАНЖУА, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн эдийн засагч

Жон-Паскал НГАНУ, Монгол Улсыг хариуцсан Дэлхийн банкны ахлах эдийн засагч
Асуулт & хариулт

10:00 - 10:10 Кофе завсарлага

10:10 - 12:00

ХУРАЛДААН 5: ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ УЯЛДАА ХОЛБОО

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран зохион байгуулж, эрчим хүчний хамтын ажиллагааны талаар бүс нутгийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид цугларан хэлэлцэнэ. Оролцогчид Зүүн Хойд Азийн орнуудын эрчим хүчний бодлого, тогтвортой хөгжил, шилдэг туршлага, ирээдүйн чиг хандлага, ойрын жилүүдэд тус бүс нутагт тулгарч болзошгүй сорилтуудын талаар санал бодлоо хуваалцах болно. Энэ хуралдаанаар Тогтвортой хөгжлийн 7 дугаар зорилт (SDG 7) болон холбогдох зорилтыг шийдвэрлэхэд тулгарч буй сорилт, боломжийг хөндөхөөс гадна бүс нутгийн эрчим хүчний уялдаа холбоог хоёр талт болон олон талт хамтын ажиллагаагаар хэрхэн хөгжүүлэх талаар ярилцана. *Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд эрчим хүчний дэд бүтцийн интеграцлал ямар нөлөө үзүүлэх вэ? Энэ чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хэрхэн илүү үр дүнтэй болгох вэ? SDG 7-д хүрэхэд тулгарч буй томоохон сорилт, бэрхшээл, шийдэл нь юу вэ? Эрчим хүчний шилжилт болон SDG7-д хүрэхийн тулд бүс нутгийн хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх вэ?*

Модератор: Ежинь ХА, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын хөтөлбөр хариуцсан ажилтан

Мэттью ВИТТЕНСТЕЙН, Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Эрчим хүчний газрын Эрчим хүчний уялдаа холбооны хэлтсийн дарга

“Зүүн хойд Азийн эрчим хүчний шилжилт ба эрчим хүчний системийн холболтын боломж: Ногоон эрчим хүчний коридор руу”

Ичинхорлоогийн ЛУВСАНЦЭРЭН, Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Дамдин-Одын ДӨЛГӨӨН, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийн гүйцэтгэх захирал

Дэвид Майкал ВОГАН, Ази, Номхон далайн эрчим хүчний судалгааны төвийн дэд ерөнхийлөгч (цахим)

Сэйичиро КИМУРА, Япон улсын Сэргээгдэх эрчим хүчний хүрээлэнгийн ахлах судлаач

Сужата ГУПТА, Зүүн Азийн газрын Тогтвортой дэд бүтцийн хэлтсийн захирал (цахим)

Жие ТАНГ, Дэлхийн банкны Эрчим хүч, олборлолтын дэлхийн практикийн менежер (цахим)

Ольга ДЁМИНА, Оросын ШУА-ийн Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан (цахим)

Сяосонг ФАНГ, Цахилгаан эрчим хүчний төлөвлөлт, инженерийн хүрээлэнгийн Олон улсын бизнесийн газрын захирал (цахим)

Асуулт& хариулт

12:00 - 13:00 Өдрийн хоол (ГХЯ, Номин танхим)

13:00 - 13:45 ХААЛТЫН ХУРАЛДААН

Модератор: Др. Жаргалсайханы МЭНДЭЭ, Стратеги судалгааны хүрээлэнгийн дэд захирал

Модераторуудын дүгнэлт (Хуралдаан 1-5)

Др. Жаргалсайханы МЭНДЭЭ, Стратеги судалгааны хүрээлэнгийн дэд захирал

Жонатан Бэркшир МИЛЛЕР, Макдоналд-Лорьер хүрээлэнгийн Энэтхэг-Номхон далайн хөтөлбөрийн захирал, ахлах судлаач

Др. Соня БАХМАН, НҮБ-ын Улс төрийн хэрэг эрхлэх газрын Зүүн хойд Ази, Номхон далайн бүсийн багийн ахлагч

Баянжаргалын БЯМБАСАЙХАН, Монголын бизнесийн зөвлөлийн дэд дарга

Ежинь ХА, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын хөтөлбөр хариуцсан ажилтан

Хаалтын үг:

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга **Нямдоржийн АНХБАЯР**

Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал, профессор **Бэгзийн ДАВААДОРЖ**

14:30 - 15:30 Монгол Улсын Ерөнхийлөгч **Ухнаагийн Хүрэлсүхтэй** дурсгалын зураг татуулна. (Олон улсын оролцогчид)

18:00 - 20:00 Олон улсын төлөөлөгчдөд зориулсан соёлын арга хэмжээ (зөвхөн урилгаар)

---oOo---